



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 1/04

Дархан

Ёс зүйн дэд хороог шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог хавсралт ёсоор шинэчлэн байгуулсугай.
2. Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг нийт бие бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.
3. Хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, ажлын тайлан, мэдээг цаг хугацаанд нь холбогдох газруудад тайлагнаж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Ёс зүйн дэд хороонд даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга (С.Туяа)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын даргын 2022 оны А/13-01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

452407010

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын
даргын 20~~04~~⁰⁴ оны ~~02~~⁰² дугаар сарын ~~07~~⁰⁷-ны өдрийн
~~1104~~¹¹⁰⁴ дугаар тушаалын хавсралт



ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

-Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн /зөвшилцснөөр/

Гишүүд:

-Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн
-Архив-бичиг хэрэг, нярав